



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/100/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:enkhbaatare@audit.gov.mn">enkhbaatare@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:bat-erdenes@audit.gov.mn">bat-erdenes@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Сүлд-Аудит" ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: <a href="mailto:info@suld-audit.mn">info@suld-audit.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1081  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төслийн хүрээнд хийгдэж буй том түвшний туршилтын төсөлд хэрэглэх зориулалттай 7 нэр төрлийн, нийт 3,611,610.0 мянган төгрөгийн үнэ бүхий, хог тээврийн машин, өөрөө буулгагч машин, бага оврын ачигч, навч цуглуулах төхөөрөмж, хатуу хог хаягдал тээвэрлэх машин зэрэг нийт 55 машин техникийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын тушаалын дагуу нийслэлийн 9 дүүргийн хот тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээний байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн нийт санхүүжилт болох 3.0 сая ам.доллаароос 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар буцалтгүй тусламжийн нийт санхүүжилт 2,997.6 мянган ам.доллар буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 2021 онд 290.0 мянган ам.доллар, 2022 онд 244.8 мянган ам.доллар, 2023 онд 452.6 мянган ам.доллар, 2024 он 2,010.2 мянган ам.долларын зарцуулалтыг тус тус гаргасан байна. Буцалтгүй тусламжийн санхүүжилтээс зарцуулаагүй үлдсэн ам.долларыг 2025 онд Азийн хөгжлийн банканд буцаан шилжүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус төсөл нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>474,531,463.70</b>	<b>7,112,888.71</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	265,705,359.13	7,112,888.71
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>265,705,359.13</b>	<b>7,112,888.71</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>259,610.30</b>	
31213	Төрийн сангийн харилцах	259,610.30	
3122	<b>Гадаад валют</b>	<b>265,445,748.83</b>	<b>7,112,888.71</b>
31221	Төрийн сангийн харилцах	265,445,748.83	7,112,888.71
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
33402	Татвар,НДШ-ийн авлага		
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>4,130,913.72</b>	
34600	Урьдчилж гарсан зардал	4,130,913.72	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>204,695,190.85</b>	
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>204,695,190.85</b>	
35410	Бичиг хэргийн материал	946,409.25	
35470	Бусад хангамжийн материал	203,748,781.60	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,235,173.70</b>	
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>13,235,173.70</b>	
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>13,235,173.70</b>	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,713,356.00	
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,713,356.00)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,678,958.18	
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,443,784.48)	
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,932,324.00	
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,932,324.00)	
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		
39301	Програм хангамж	880,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000.00)	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>487,766,637.40</b>	<b>7,112,888.71</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>516,396.23</b>	
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	516,396.23	
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>516,396.23</b>	
413100	Ажилчидтай холбогдсон өглөг	199,561.23	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>316,835.00</b>	
41361	Байгууллагад төлөх өглөг	316,835.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>487,250,241.17</b>	<b>7,112,888.71</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>487,250,241.17</b>	<b>7,112,888.71</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>487,250,241.17</b>	<b>7,112,888.71</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	746,108,173.50	487,250,241.17
51220	Тайлант үеийн үр дүн	(258,857,932.33)	(480,137,352.46)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>487,766,637.40</b>	<b>7,112,888.71</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,227,975,356.91</b>	<b>6,986,123,500.69</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,227,975,356.91</b>	<b>6,986,123,500.69</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>45,957,028.36</b>	<b>428,730,336.18</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,957,028.36	428,730,336.18
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,957,028.36	428,730,336.18
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>1,182,018,328.55</b>	<b>6,557,393,164.51</b>
122002	Хандив тусламж /гадаад/	1,182,018,328.55	6,557,393,164.51
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,464,976,262.50</b>	<b>7,455,037,797.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,464,976,262.50</b>	<b>7,455,037,797.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,464,976,262.50</b>	<b>7,455,037,797.69</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>223,770,818.00</b>	<b>290,710,000.00</b>
210101	Үндсэн цалин	223,770,818.00	290,710,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,971,353.00</b>	<b>36,257,188.32</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,971,353.00	36,257,188.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,759,154.09</b>	<b>55,542,802.97</b>
210304	Байрны түрээс	35,759,154.09	55,542,802.97
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,490,576.63</b>	<b>43,903,449.02</b>
210401	Бичиг хэрэг	5,702,449.78	12,561,354.89
210402	Тээвэр, шатахуун	18,832,922.11	27,062,235.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,955,204.74	4,279,858.63
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,098,048,301.75</b>	<b>2,308,011,724.56</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,085,292,921.46	2,277,830,590.41
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,890,000.00	27,000,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,865,380.29	2,855,704.40
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		325,429.75
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>48,936,059.03</b>	<b>4,720,612,632.82</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,995,545.60	4,719,233,293.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,940,513.43	1,379,339.52
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(237,000,905.59)</b>	<b>(468,914,297.00)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>12,425,493.20</b>	<b>3,049,699.34</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	12,425,493.20	3,049,699.34
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>34,282,519.94</b>	<b>14,272,754.80</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	14,384,519.94	2,416,920.62
225012	Хөрөнгө оруулалтын зориулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зорилготой хөрөнгийн зардал	19,898,000.00	11,855,834.18
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(21,857,026.74)</b>	<b>(11,223,055.46)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(258,857,932.33)</b>	<b>(480,137,352.46)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>654,800,108.20</b>	<b>1,886,314,061.37</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>654,800,108.20</b>	<b>1,886,314,061.37</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>654,800,108.20</b>	<b>1,886,314,061.37</b>
122002	Хандив тусламж /гадаад/	654,800,108.20	1,886,314,061.37
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,035,131,019.18</b>	<b>1,939,706,309.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,035,131,019.18</b>	<b>1,939,706,309.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,035,131,019.18</b>	<b>1,939,706,309.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>220,610,000.00</b>	<b>286,142,050.22</b>
210101	Үндсэн цалин	220,610,000.00	286,142,050.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,966,552.25</b>	<b>36,600,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,966,552.25	36,600,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,685,222.81</b>	<b>48,281,999.72</b>
210304	Байрны түрээс	33,685,222.81	48,281,999.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,031,024.84</b>	<b>36,810,764.90</b>
210401	Бичиг хэрэг	4,951,256.96	6,254,999.90
210402	Тээвэр, шатахуун	16,600,000.00	26,393,765.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,479,767.88	4,162,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>725,438,719.28</b>	<b>1,531,871,494.67</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	711,395,792.66	1,509,846,064.92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,900,000.00	17,500,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	4,142,926.62	4,200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	325,429.75
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>399,500.00</b>	<b>0.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	399,500.00	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(380,330,910.98)</b>	<b>(53,392,248.14)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>205,833,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>205,833,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>205,833,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж		205,833,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b>(205,833,000.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,959,026.74)</b>	<b>632,778.72</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	12,425,493.20	3,049,699.34
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(14,384,519.94)	2,416,920.62
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(382,289,937.72)</b>	<b>(258,592,469.42)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>647,995,295.85</b>	<b>265,705,359.13</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>265,705,359.13</b>	<b>7,112,888.71</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>746,108,173.50</b>	<b>746,108,173.50</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	<b>746,108,173.50</b>	<b>746,108,173.50</b>
Тайлант үеийн үр дүн		(258,857,932.33)	(258,857,932.33)
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>487,250,241.17</b>	<b>487,250,241.17</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	<b>487,250,241.17</b>	<b>487,250,241.17</b>
Тайлант үеийн үр дүн	-	(480,137,352.46)	(480,137,352.46)
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>7,112,888.71</b>	<b>7,112,888.71</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,431,754,723.24</b>	<b>6,816,292,982.90</b>	<b>(2,384,538,259.66)</b>	<b>153.8</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	2,402,519,582.27	3,531,364,528.35	(1,128,844,946.08)	147.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,402,519,582.27</b>	<b>3,531,364,528.35</b>	<b>(1,128,844,946.08)</b>	<b>147.0</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,480,000.00	286,142,050.22	(63,662,050.22)	128.6
Үндсэн цалин	222,480,000.00	286,142,050.22	(63,662,050.22)	128.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,810,000.00	36,600,000.00	(8,790,000.00)	131.6
Тэтгэврийн даатгал	27,810,000.00	36,600,000.00	(8,790,000.00)	131.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,330,600.00	48,281,999.72	(5,951,399.72)	114.1
Байрны түрээс	42,330,600.00	48,281,999.72	(5,951,399.72)	114.1
Хангамж, бараа материалын зардал	33,160,000.00	36,810,764.90	(3,650,764.90)	111.0
Бичиг хэрэг	6,400,000.00	6,254,999.90	145,000.10	97.7
Тээвэр, шатахуун	20,160,000.00	26,393,765.00	(6,233,765.00)	130.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,600,000.00	4,162,000.00	2,438,000.00	63.1
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,659,473,352.69</b>	<b>3,123,529,713.51</b>	<b>(1,464,056,360.82)</b>	<b>188.2</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,630,273,352.69	3,101,829,713.51	(1,471,556,360.82)	190.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	25,000,000.00	17,500,000.00	7,500,000.00	70.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200,000.00	4,200,000.00	-	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>417,265,629.58</b>	-	<b>417,265,629.58</b>	<b>0.0</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	417,265,629.58	-	417,265,629.58	0.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,029,235,140.97</b>	<b>3,284,928,454.55</b>	<b>(1,255,693,313.58)</b>	<b>161.9</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,029,235,140.97</b>	<b>3,284,928,454.55</b>	<b>(1,255,693,313.58)</b>	<b>161.9</b>
Барилга байгууламж	430,536,250.00		430,536,250.00	0.0
Тоног төхөөрөмж	1,598,698,890.97	3,284,928,454.55	(1,686,229,563.58)	205.5
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,431,754,723.24</b>	<b>6,557,393,164.50</b>	<b>(2,125,638,441.26)</b>	<b>148.0</b>
<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>4,431,754,723.24</b>	<b>6,557,393,164.50</b>	<b>(2,125,638,441.26)</b>	<b>148.0</b>
Хандив тусламж /гадаад/	4,431,754,723.24	6,557,393,164.50	(2,125,638,441.26)	148.0
Төсвийн тохируулгын дүн		307,347.98		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>265,705,359.13</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>7,112,888.71</b>		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>5</b>	<b>5</b>	-	<b>100.0</b>
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.0

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 147,490.6 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөг/*

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн зөрүүтэй тайлагнасан.	1	307.3			1	307.3	1	307.3				
Мөнгөн гүйлгээний тайлангийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн тохируулгын тайлангаарх дүнгээс зөрүүтэй тайлагнасан.	1	116,816.6			1	116,816.6	1	116,816.6				
Тайлант хугацааны үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг Засгийн газраас чөлөөлж буй НӨАТ-ын тайлангаарх дүнгээс	1	30,366.7			1	30,366.7	1	30,366.7				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>200,463.0</b>			<b>4</b>	<b>200,463.0</b>	<b>4</b>	<b>200,463.0</b>				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 3,520.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 3,520.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалингийн бүрэлдэхүүнийг 3,520.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	3,520.0					1	3,520.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,520.0</b>					<b>1</b>	<b>3,520.0</b>				

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснийг хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, ирүүлээгүй байна.	1	-							1		1	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>							<b>1</b>		<b>1</b>	

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.